



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2018 сны 06 сарын 14 өдөр

Дугаар A/180

Улаанбаатар хот


Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.2, “Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2016 оны 12 дугаар тогтоол, Засгийн газрын 2016 оны 4 дүгээр тогтоолыг тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай” Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2016 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А/32 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан Цаг уур, орчны шинжилгээний газрын бүтцэд “Удирдлага, төлөвлөлт, санхүү, хамтын ажиллагааны хэлтэс” гэснийг “Захиргаа, аудитын хэлтэс”, “Санхүү, төлөвлөлт, хамтын ажиллагааны хэлтэс” гэж өөрчилсүгэй.

2. Агентлагийн зохион байгуулалтын бүтцэд орсон өөрчлөлтийг Цаг уур, орчны шинжилгээний газрын батлагдсан төсөвтөө багтааж, төсөв, зардал, орон тоог нэмэгдүүлэхгүйгээр зохион байгуулж ажиллахыг Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга С.Энхтувшинд үүрэг болгосугай.

САЙД



Н.ЦЭРЭНБАТ